

МОНГОЛ ХЭЛНИЙ АСУУХ ТӨЛӨӨНИЙ ҮГИЙН
ӨГҮҮЛБЭРТ ГҮЙЦЭТГЭХ УТГА, ҮҮРЭГ

Т.Энх-Амгалан⁶²

Товч агуулга: Монгол хэлний төлөөний үг тэр дундаас "яах" хэмээх асуух төлөөний үгийн өгүүлбэрт хэрэглэгдэх бүтэц, илэрхийлэх утга, гүйцэтгэх үүргийг уран зохиолын жишээ баримтад тулгуурлан авч үзсэн болно.

Түлхүүр үг: төлөөний үг, асуух төлөөний үг, төлөөний үгийн өгүүлбэрт илрэх байдал.

Хэлшинжлэлийн бүтээлүүдэд төлөөний үгийг аливаа зүйлийг шууд заан нэрлэхээс гадна шууд нэрлэхгүй зөвхөн төлөөлүүлэн хэлэх, ялгах, асуух утгатай бүлэг үгс хэмээн эрдэмтэд тэмдэглэсээр иржээ. Тухайлбал: "туйлын хийсвэр бөгөөд маш ерөнхий утга санаа илтгэдэгээрээ их өвөрмөц юм. Жишээ нь: ширээ сандал гэхэд чухам юу зааж, ямар утга илтгэж байгаа нь тодорхой байхад энэ, тэргэх үг нь юу зааж ямар санаагаар хэрэглэж байгаа нь тодорхой биш байна. Энэ, тэр гэх үг нь тухайн хэрэглэгдэх байдлаас болж ямар ч зүйлийг заан төлөөлсөн байж болно"⁶³. "Юм ба түүний бэлэг чанарыг шууд нэрлэхгүй зөвхөн төлөөлөн хэлэх, ялган заах, асуун лавлах зэргийн утга илтгэх хэсэг үгсийг төлөөний үг" гэнэ гээд а) "*би, чи, та, тэр, бид, эд, тэд...*" гэхмэтбиеийг заан төлөөлөх биеийн төлөөний үг, б) "*энэ, тэр, ийм, тийм, өдий, төдий, өчнөөн, төчнөөн, энд, тэнд, ийш, тийш, ингэх, тэгэх*" гэх мэт хүн ба юм түүний шинж чанар, тоо хэмжээ, орон цаг, үйл явдал зэргийг шууд ялган заадаг заах төлөөний үг, в) "*хэн, юу, аль, ямар, хир, хэд, хичнээн, яах, хаа, хэзээ, хэдийд*" гэх мэт хүн ба юм түүний бэлэг чанар тоо, хэмжээ, үйл явдал, түүний хаа хэзээ болсныг лавлан асуусан утга бүхий асуух төлөөний үг, г) "*хэн ч, юу ч, аль ч, ямар ч, ямар чиг, ямар нэгэн, хэд ч, хичнээн ч, хаа ч, хаана ч, хэзээ ч, хэдийд ч, яах ч*" гэх мэт аль нэгэн үл мэдэгдэх хүн ба юм, түүний бэлэг чанар, тоо хэмжээ, үйл явдал түүний хаа хэзээ болсон зэргийг нийтэд нь заасан үгсийг тодорхойгүй төлөөний үг, д) "*бүгд, цөм, булт, нийт, бүр, зарим, өөр, ондоо, хамт*" гэх мэт аль нэгэн хүн ба юмны бүхэл бүтэн, хагас дутуу, мөн бус зэргийг тодотгон заах үгийг ялгах төлөөний үг, е) "*өөрөө*" гэх мэт орчин цагийн монгол хэлэнд үйлийн эзэн өөрийгөө төлөөлөн хэлэх энэ үг нь хоёр ба гуравдугаар биеийн аль алиныг заан төлөөлж чадах энэ үгийг өөрийн төлөөний үг гэнэ [Төмөрцэрэн Ж. Төлөөний үг-Орчин цагийн монгол хэлний зүй, 1966, 199] гэсэн бөгөөд төлөөний үгийн утга, үүргийн онцлогийн талаар хэл судлаач эрдэмтэн М. Базаррагчаа, Б. Пүрэв-Очир, Ц. Цэдэндамба, Ю. Мөнх-Амгалан, З. Гулираанз, Ц. Оюун, Ө. Мөнхдолгор нарын бүтээлд туссан байдаг.

Монгол хэлний асуух төлөөний үгийн гүйцэтгэх үүрэг нь маш олон талтай, хэрэглэгдэх хэмжээ нь туйлын өргөн юм. Асуух төлөөний үгийн гүйцэтгэх үүрэг болон хэлзүйн шинж чанараар нь хэд хэдэн зүйл болгон ялган үзэж болно. Тухайлбал: *Хэн?, юу?* гэх асуух төлөөний үгийг гол төлөв жинхэнэ нэрийн зүйлд хэрэглэх бөгөөд хэн гэдгийг хүн төрөлхтөнд хэрэглэж, юу гэдгийг хүн төрөлтөнөөс бусад зүйлд хэрэглэнэ.

⁶²МУИС,ШУС, Хүмүүнлэгийн салбар, Хэл Шинжлэлийн тэнхимийн докторант

⁶³ШУА-ийн ХЗХ-ээс эрхлэн гаргасан "Орчин цагийн монгол хэлний зүй" УБ., 1966

Жишээ нь: **Хэн байна? Захирал байна. Хэн хийх вэ? Бат хийнэ. Уулнаас юу авав?** Уулнаас мод авав. гэх мэт. Хэн юу гэж асуух төлөөний үг нь ганц ба олон тоо ялгаж, энгийн ба хамаатах зүүвэртэй тийн ялгалаар ялгалагдана. Жишээ нь: **Хэн хэн ирэв Юу юу авав Хэний? Юуны? Хэнд? Юунд? Хэнийг? Юуг? Хэнээс? Юунаас? Хэнээр? Юугаар? Хэнтэй? Юутай? Хэнрүү? Юуруу?** гэх мэт өгүүлбэрт гол төлөв өгүүлэгдэхүүн буюу тусагдахуун гишүүн болно. Жишээ нь: **Таны нэр хэн бэ? Та энд юу хийдэг вэ?** Хэн юу гэдэг нь өөрийн шинж чанараараа жинхэнэ нэртэй ойр байдаг. Аль? гэх асуух төлөөний үгийг нэг төрлийн олон юмны дотороос аль нэгийг ялгаж тодорхойлоход хэрэглэдэг. Жишээ нь: **Аль замаар явах вэ? Аль гэрт суудаг вэ?** гэх мэт. Аль гэх асуух төлөөний үгийг ганц ба олны хэлбэрээр хэрэглэж энгийн ба хамаатуулах тийн ялгалын зүүврээр хувиргаж болно. Жишээ нь: **Аль алинаас нь авах вэ? Аль аль даргатай уулзах вэ?** гэх мэт. Аль гэдэг нь өгүүлбэрт гол төлөв тодотгол буюу тусагдахуун гишүүн болдог. Жишээ нь: **Тогоо аль аймгийн хүн бэ? Та алиныг нь авах вэ?** гэх мэт. Ямар? гэдэг асуух төлөөний үгийгхүн юмны бэлэг чанар үйл явдлын хэрхэн болсныг лавлан асуухад хэрэглэнэ. Жишээ нь: **Ямар зүсмийн морь вэ? Саарал зүсмийн морь. Ямар явав даа? Сайн явлаа** гэх мэт. Ямар гэдэг нь ганц ба олон тоог ялган зааж, тэмдэгийн нэрийн адил тийн ялгалаар ялгагдана. Жишээ нь: **Ямар ямар ном байна? Ямар ямар хүн ирж вэ?** гэх мэт. Өгүүлбэрт гол төлөв тодотгол буюу байц гишүүн болдог. Жишээ нь: **Ямар өндөр уул вэ? Гомбын би нь ямар байна** гэх мэт. Мөн тэмдэг нэрийн адил шиг, рхуу дагавар залгаж болдог. Жишээ нь: ямар шиг, ямархуу гэх мэт. Хир? гэдэг асуух төлөөний үгийг хүн юм, үйл явдал, чанар хэмжээг илтгэн тодорхойлоход хэрэглэгдэнэ. Жишээ нь: **Нямбуу хуучин бичиг хэр мэдэх вэ? Загд чинь хир хүн бэ дээ?** гэх мэт. Орчин цагийн монгол хэлэнд хир гэдгийг зохих үгтэй холбон аль хир? Хир зэрэг? гэх мэтчилэн хэлэлцэх болсон. Хир гэх асуух төлөөний үгийг олон тооны хэлбэрээр хэрэглэх нь ховор байдаг. Харин бусад үгтэй хоршин тийн ялгалаар ялгагдана. Өгүүлбэрт гол төлөв байц гишүүн болно. Жишээ нь: **Дамбий тэргээ аль хир зассан бэ? Наадам дээр хир зэрэг хүн цугласан бэ?** гэх мэт. Яах? гэх асуух төлөөний үгийг хүн юмны үйл байдлыг лавлан асуухад хэрэглэнэ. Жишээ нь: **Долгор яагаад ажилд ирээгүй бол? Эрт өдрийн ажил одоо яасан бэ? Чи тэмцээнд оролцохгүй яав?** Яах гэдэг нь өөрийн шинж чанараар үйл үгтэй адил бөгөөд өгүүлбэрт гол төлөв байц буюу өгүүлэхүүн гишүүний үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь: **Яаж оролдвол гадаад хэл түргэн сурах вэ? Лувсан захидал бичихгүй яагаа вэ?** гэх мэт. [Төмөрцэрэн Ж. Төлөөний үг-Орчин цагийн монгол хэлний зүй, 1966, 199] гэж ангилсан бол эрдэмтэн Ю. Мөнх-Амгалан **аль, хэ-** язгуурт үгсийн үүрэг утгазүйг дараах байдлаар онцлон үзсэн байна. Жишээ нь: **Аль+бол-**туслах үйл үг гэсэн загвараа харьцангуй олон хам бүтэц бүтдэг хэмээгээд энэ нь дараах утга, үүрэгтэй байж болно. Тухайлбал: 1. Тэмдгийн нэрийн өмнө нэгэн зүйл тодотгол болон орж **аль болох** богино хугацаа, **аль болох** хол газар, **аль болох** өөдрөг сэтгэл, **аль болох** залуу нохой, **аль болох** тайван амьдрал гэх мэтээр юмс үзэгдлийн боломжит хэмжээ хязгаар заасан холбоо үгийн бүрэлдэхүүнд орж идэвхтэй хэрэглэгдэнэ. 2. Өгүүлэхүүний өмнө тохиолдож “тухайнхэрэгюм, үйлийн “**аль чадахаар, аль болохоор**” болох байдлыг илтгэнэ” [Б. Ваанчиг 1990,27] Жишээлбэл: Би чинь **аль болохоор** зовлонгоо л ойлгуулаад байна гэж бодсон чинь цаанаа зарим нэг нь доог тохуу хийж явдаг байгаа даа [Д. Баасанбаяр].

Монголч эрдэмтдийн арав гаруй хэлзүйн номонд дурдагдсан хориод асуух төлөөний үгийн үндсэн хэлбэрийг ажиглахад эдгээр нь ХЭ-(хэн, хэд(эн), хэзээ, хэр зэрэг, хичнээн, хэдий(д), хэрхэн, хэдий чинээ), Хаа-(хаа(на), хааг, хаанаас, хаагуур, хаашаа, хаач-), Я-

(Ю-)(ямар, яа, юу), Аль-(аль, альхи, алив(аа), алид) гэсэн хэв шинжийн хувьд дөрвөн зүйл язгууртай болох нь бүртгэгдсэн билээ.

Утга зохиол болон хэлний жишээ баримтаас харахад Я-, Ю- хэмээх асуух төлөөний үгийн утга болон өгүүлбэрт гүйцэтгэх үүргийг дараах байдлаар ялган үзэж болмоор байна. Энэхүү төлөөний үгийн үндсэн утга үүргийн тухайд монгол хэлний хэлзүйн зонхилох бүтээл хийгээд тайлбар толь бичигт дурдахдаа “асуух, лавлах, ялгах, заахутгаар...” [Я. Цэвэл. 1966, 36], “...нэг төрлийн олон юмны дотроос аль нэгийг ялгаж тодорхойлоход хэрэглэдэг” [Ж. Төмөрцэрэн. 1966, 205], “...ялган асуух үг...” [Ш. Лувсанвандан, 1968, 88], “...олон юмны дотроос нэгий нь ялган тодорхойлоход хэрэглэнэ” [П. Бямбасан. 1975, 94], “...шинж чанарыг асуух буюу...нэг төрлийн олон юмны дотроос нэгий нь ялган асуухад хэрэглэнэ” [Л. Балдан. 1987, 81], “...тухайн хэрэг юмыг ялган асуух” [Б. Ваанчиг 1990, 25], “...шинж чанар, бэлгэ тэмдэгийг...онцлон ялгаж асуух” [Ц. Өнөрбаян. 1994, 214], “...хүн юмны алиныг ч асуух” [Чингэлтэй 1999, 216], “...голдуу нэг төрлийн олон юмны дотроос нэгийг нь ялган асуух...” [Хас-Эрдэнэнэр. 1996, 309], “...хэрэг учрыг сонгон асуух...” [Батгэрэл. 2001, 367], “...бүхнийг (хүнээс бусад) Ю. Мөнх-Амгалан) ялган харилцаж асуух, тодорхой төлөөлсөн үглэвэр” [М. Базаррагчаа. 2005, 163] гэхмэтээр ихэвчлэн хэлний бүтэц, тогтолцооны норматив стандарт талаас нь товчоолон тодорхойлжээ.

ЯАХ гэх асуух төлөөний үгийн хувьд хүн юмны үйл байдлыг лавлан асуухад хэрэглэнэ. Жишээлбэл:

Чиний нөгөө өгнө гэсэн ном чинь яав? (ерийн асуусан) ↔ Чиний нөгөө өгнө гэсэн ном чинь яав аа? (...) гэх мэт.

Бидний илтгэлийн гол зорилго нь: Монгол хэлний ЯАХ хэмээх асуух төлөөний үгийн өгүүлбэрт гүйцэтгэх утга, үүргийг илрүүлэх билээ. ЯАХ хэмээх асуух төлөөний үгийн утга үүргийг илрүүлэхдээ судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож Д. Намдагийн жүжгийн зохиолын түүвэр, Монголын сонгомол өгүүллэг хэмээх бүтээлээс нийт 635 нэгж түүвэрлэн ажиглалт хийхэд дараах утгуудыг илрүүлж байна.

Яах вэ хэмээх асуух төлөөний үг нь нь хэлэхийн явцад *за яах* вэгэдэг хэлбэр үүсгэх бөгөөд энэ нь дараах утга илэрхийлсэн байна. Үүнд:

1. Яах вэ гэх үгийн нэг өвөрмөц утга болох *тухайн зүйлд сэтгэл дундуур байдалтай зөвшөөрсөн утга илтгэнэ*. Жишээлбэл:

За яах вэ: За яах вэ, би чамд худгийн тухай нэг үг ярихыг больё. (Д. Намдаг 1987, 48), *...Яах вэ яах вэ*, яваад амраагаад өгье. (Д. Намдаг 1987, 197)

2. *За яах вэ* гэдэг нь ярианы хэлэнд *тухайн ярьж буй зүйлийг орхин өөр зүйлд анхаарах үед эргэлзэж тээнэгэлзсэн утгаар хэрэглэгдэж болно*. Жишээлбэл:

...Бидний ардууд хурал дээр гар өргөх боловч гэртээ ирээд багаж яах билээ энэ тэр гэж баахан ярьж байгаад зүгээр суудаг заншилтай болоод байна... *За яах вэ*, тэгээд худаг малтах болов уу? (Д. Намдаг 1987, 50)

3. *Яах вэ* гэдэг нь мөн *хамаагүй гэсэн утгыг илтгэдэг байна*. Жишээлбэл:

За тэр нар, сар, од, мичид ч *яах вэ*. Би ч чамд л хайртай болсон байна... (Д. Намдаг 1987, 287)

4. *Яах вэ* гэдэг нь зарим тохиолдолд *юмны хэмжээ хязгаарыг тогтоох утга илтгэж болно*. Жишээлбэл:

Миний хүслээр бол зүү орох зайгүй зууралдаад ч *яах вэ*, зүгээр хэн хэн нь уран зөөлөн үгтэй үзэсгэлэнтэй хүнийг хараад салах суух, урвах сэтгэл төрөхгүй, бие биеэ эн тэгш хайрлан хамгаалж явбал барав. (Д. Намдаг 1987, 192)

5. *Яах вэ* гэдэг нь мөн *боломжийн гэсэн аливааг үнэлсэн үнэлгээний утга илтгэнэ*. Жишээлбэл:

...Адуу *яах вэ дээ*, хуучин хэвэндээ сайхан орсон, отор нүүдэл ч их хийсэн. Үхэр хонь төдий л сайнгүй...(Д. Намдаг 1987, 300)

6. *Яах вэ* хэмээх асуух төлөөний үг нь *батлах утгат баймж үгтэй хам бүтэц* үүсгэн тухайн илэрхийлж буй зүйлийг *тааламжтай зөвшөөрөх утга илтгэнэ*. Жишээлбэл: ...одоо даруй авчирвал болно доо. Тэгэлгүй *яах вэ*...би жолоочийг явуулъя. (Д. Намдаг 1987, 202), Иш мэдэлгүй *яах вэ*, ахайтаан...(Д. Намдаг 1987, 282)

Яах вэ гэх асуух төлөөний үг нь өгүүлбэр болон эхийн дотор холбох үгийн үүргээр хэрэглэгдэх нь тохиолдож байна.

1. Энэ хэлбэр нь энгийн өгүүлбэрүүдийн хооронд тохиолдохдоо аль нэг өгүүлэмжийг учирлан тайлбарласан утга илэрхийлж байна.

Жишээлбэл: Миний хүслээр бол зүү орох зайгүй зууралдаад ч *яах вэ*, зүгээр хэн хэн нь уран зөөлөн үгтэй үзэсгэлэнтэй хүнийг хараад салах суух, урвах сэтгэл төрөхгүй, бие биеэ эн тэгш хайрлан хамгаалж явбал барав. (Д. Намдаг 1987, 192)

2. Энэ хэлбэр нь өгүүлбэрийн эхэнд тохиолдвол тухайн өгүүлбэрээ өмнөх цогцолбортой нь холбон эхийн гадаад холбох үүрэг гүйцэтгэн утгыг зөөллөн нэмэн дэлгэрүүлж тайлбарласан утгатай байна. Жишээлбэл: ...Тэгээд юугаа нуусан юм бэ? ингэж намайгаа итгэхгүй болсон чинь юу вэ? Нөгөө янаг амраг сэтгэл чинь хаачив? ...*За яах вэ*би чамд хэлье. Ажлын явц муу болов гэж манай албаны ажилчид нийтээр сүрхий шүүмжилж байна.....(Д. Намдаг 1987, 224)

Ажиглалтаас үзэхэд, ихэвчлэн ярианы хэлэнд *яах вэ* хэмээх үг дангаараа хүн, юм үзэгдэл, тэдгээрийн шинж тэмдэг, бэлгэ чанар зэрэгд эргэлзсэн, гайхсан, тээнэгэлзсэн утгыг илэрхийлсэн байдаг. Жишээлбэл: Энэ хүндтэй шагналыг урд өмнө удаагүй, олны өмнө онц тод ажлыг хийгээгүйгээрээ хүлээн авахад халуухан л байна шүү дээ...*За яах вэ*, та тэгж бодож байгаа бол тэр бүхнийг та лав бүтээж чадна биз гэж би итгэж байна...(Д. Намдаг 1987, 193)

Яах+н хэмээх үг нь хэрэг юмыг хийж бүтээхэд зайлшгүй хэрэгтэй зүйл эсвэл болохгүй гэсэн утга илтгэх бөгөөд үүнийг *яахин орхиж болох билээ, яахин мартаж билээ, яахин өгөх билээ, яахин болох билээ, яахин хийх билээ*...гэх зэрэг үгээр солин хэрэглэж болохоос гадна өгүүлэмжийнхээ хүрээнд дараах утгыг илэрхийлж болно.

1. **ЯАХ+Н+Үйл** үг гэсэн загвараар хам бүтэц үүсгэн хам бүтцэд орсон үйл үгийн утгыг сөргүүлэн эрчимжүүлэх утга илтгэдэг байна. Жишээлбэл: ...үлдсэн ганц нэг нь залуудаа салхи сар, үүл борооны явдал хийж явсан ганган түшмэлийг одоо энэ дэлгүүрийн манаач болоод хүүхэн тэвэрдэг цог нь хэдийн өнгөрч, тучин жил дуугараагүй хуучин бярдан буу тэврэн, дэлгүүрийн үүдэнд үүрэглэн хонодгийг *яахин*мэдэх аж...

2. **Яах+Н+даруй** гэсэн бүтэц нь өгүүлбэрт богино хугацаа гэсэн цагийн утга илтгэдэг байна. Жишээлбэл: Хөндий талын зэрэглээ мяралзан жирвэгнэхийн дунд хэдэн өндөр юм сүүмэлзэн үзэгдэх нь харь газрын хүний нүдэнд *яахин даруй* танигдана.... (Д. Нацагдорж 2005, 22) гэх мэтийн жишээ баримтаас үзэхэд ЯАХ хэмээх асуух төлөөний үг нь цагийн баймж утга илтгэж байгаа нь илэрхий юм.

ДҮГНЭЛТ

1. Монгол хэлний ЯАХ- хэмээх асуух төлөөний үг нь өмнөө болон ардаа авах үгээсээ шалтгаалан үл мэдэг уцаарлан зөвшөөрсөн, нэхэн шаардсан, тааламжгүй шаардсан сэтгэлийн байдлыг илэрхийлсэн байна.
2. Эцэст нь нэгтгэн үзвээс монгол хэлний ЯАХ- хэмээх асуух төлөөний үг болон ийм үг бүхий задлаг хам бүтэц, нийлмэл хэлбэр нь ХЭ-, АЛБ ч язгуурт асуух төлөөний үгийн нэгэн адил асуун төлөөлөх ерөнхий утгын зэрэгцээ үйл хөдлөл болон янз бүрийн утга илэрхийлэх тэрчлэн хандсан болоод аялга үг, нийлмэл өгүүлбэрийн харилцан шүтэлцээт холбоос, эхийн холбох хэрэглүүрийн үүргээр хэрэглэгддэг байна.
3. ЯАХ+Н+даруй хэмээх асуух төлөөний үг нь хам бүтэц үүсгэж буй үгээсээ шалтгаалан янз бүрийн баймж утгыг илэрхийлдэг нь хэлний баримтаас харагдаж байна.
4. ЯАХ хэмээх асуух төлөөний үгийг өгүүлбэрт олон тооны хэлбэрээр хэрэглэх нь ховор юм.

НОМЗҮЙ

1. Алтанцэцэг М, Эрдэнэ А. “Хэзээ” хэмээх асуух төлөөний үгийн нутга, үүрэг, хэрэглээний зарим онцлог, “Монгол хэл шинжлэл”. ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Боть IX (XXXI). УБ. 2006.
2. Базаррагчаа М. “Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр”. УБ. 1993.
3. Базаррагчаа М. “Монгол хэлний нэгжүүдийн харьцаа холбоо”. Гурван-Эрдэнэ БДС-ийн ЭШБ №2. УБ. 2000.
4. Базаррагчаа М. “Монгол хэл”. УБ. 2000.
5. Базаррагчаа М. “Монгол хэлний өгүүлбэрсудлал”. УБ. 2005.
6. Балдан Л. “Орчин цагийн монгол хэлний үгт зүйн байгуулал”. УБ. 1987.
7. Бямбасан П. “Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг”. УБ. 1975.
8. Мөнх-Амгалан Ю. “Монгол хэлний АЛБ хэмээх асуух төлөөний үгийн нүүрэг-утга зүйн онцлог”. МУИС. МХХСЭШБ №226. XXVI. УБ. 2006.
9. Мөнх-Амгалан Ю. “Монгол хэлний ХЭ- язгуурт асуух төлөөний үгийн нүүрэг-утга зүйн онцлог”. МУИС. МХХСЭШБ №285. XXVII. УБ. 2007.
10. Мөнхдолгор Ө.
“Монгол хэлэндэх өгүүлбэр зүйн зэрэгцсэн гишүүдийг ерөнхийлөн товчлох арга”/Докт. Дисс/. УБ. 2001.
11. ШУА. ХЗХ. “Орчин цагийн монгол хэлний зүй”. УБ. 1966.
12. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний зүй”. УБ. 1998.
13. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний үг зүй”. УБ. 1994.
14. Пүрэв-Очир Б, Мөнх-Амгалан Ю, Гулираанз З. “Монгол хэлний энгийн өгүүлбэр-эхийн онол практикийн зарим асуудал”. III дэвтэр. УБ. 1995.

SUMMARY

Issues of pronoun in Mongolian language indicate meaning of demonstrative pronoun, interrogative pronoun and distinguishing pronouns. Interrogative and distinguishing pronouns haven't been studied a lot thus we emphasize forms and functions in the sentences.